



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 дугаар сарын 16 өдөр

Дугаар 24

Хэрлэн сум

XIV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 24 дүгээр хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 82,6 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2.2.Хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу орох зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 23:00-06:00 цаг хүртэл хязгаарласантай холбогдуулан аймгаас гарах хөдөлгөөнд зохицуулах хийх, баталгаат бус замын хөдөлгөөнд хяналт тавих талаар санал танилцуулах,

Цагдаагийн газар

2.3.Ноолуур бэлтгэлт, худалдан авалт хийхэд тавих хяналтын талаар хэлэлцэх,

Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар

2.4.Гэрийн тусгаарлан ажиглалтын явц, /буудал/ авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

2.5.Цаг агаарын аюулт үзэгдлийн үед аймгийн хэмжээнд гарсан гамшгийн төрөл, учирсан хохирлын талаар мэдээлэл танилцуулах, цаашид анхаарах асуудлууд талаар хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2.6.Гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, эргүүл ажиллуулах, сэтгүүрээр хангах талаар хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

Байгаль орчин аялал жуулчлалын газар

2.7.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичиг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар


/ Ч.Ганбат
 / Д.Баттулга

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.1.Салбар хоорондын уялдааг хангах, иргэдэд шуурхай үйлчлэх, хяналт, шалгалтын ажлыг эрчимжүүлэх талаар шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдийн ахлагч нарт чиглэл өгөхийг,

“Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын дарга,
Онцгой комиссын гишүүн Б.Баярсайхан-д:

1.2.Хөлөнбуйр сумын Эхийн амаржих байрны засварын ажлыг шийдвэрлэхийг,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,
“Чойбалсан хөгжил” ОНӨҮГ-ын дарга А.Амарцэнгэл нарт:

1.3.Баянтүмэн сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгийн ариун цэврийн байгууламж, хогны цэгийг засварлаж ашиглалтанд оруулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:


1.4.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ажиллаж буй албан хаагч нартай уулзаж санал сонсох, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах талаар анхаарах, тухай бүрт нь зааварчилгаа өгч ажиллахыг,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1.Нийслэлийн Засаг даргын захирамжаар Улаанбаатар хот руу нэвтрүүлэх хөдөлгөөнд цагийн хязгаарлалт тогтоосонтой холбогдуулан эрүүл мэндийн яаралтай түргэн тусламж, буяны ажил, бусад хүндэтгэн үзэх шалтгаан /албан томилолт/-тай суудлын автомашинаар зорчиж буй иргэд 3,5 тн хүртэлх В ангилалын тээврийн хэрэгслээр өдөр бүр 06:00-11:00 цагийн хооронд Баянтүмэн, Баян-Уул сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр зорчуулахыг, ачаа тээвэрлэлтэд цагийн хязгаарлалт тогтоолгүй халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлэх тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргахыг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:

2.2.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрээгүй баталгаат бус замаар хөдөлгөөнд оролцсон тээврийн хэрэгсэлд хяналт тавих, зөвшөөрөлгүй тээврийн


/ Ч.Ганбат
/ Д.Баттулга

хэрэгслийн жолооч нарт зохих хууль, дүрмийн дагуу арга хэмжээ тооцож ажиллахыг,

Баян-Уул, Цагаан-Овоо, Хөлөнбуйр, Матад сумын Засаг дарга,
Онцгой комиссын дарга нарт:

2.3.Баян-Уул, Цагаан-Овоо, Хөлөнбуйр, Матад суманд шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрээгүй баталгаат бус замаар хөдөлгөөнд оролцсон, зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслийг хянах зорилгоор 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл хөдөлгөөнт эргүүл томилж ажиллуулахыг,

Гурав.Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ж.Алимаа-д:

3.1.Ноолуур худалдан авах ажилд хяналт тавих зорилгоор Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулах, удирдамж боловсруулан батлуулж ажиллахыг,

Аймгийн Онцгой комиссын гишүүдэд:

3.2.Сумд хариуцсан Онцгой комиссын гишүүд сумын Онцгой комисстой тогтмол холбогдож мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч мэдээ мэдээллээр хангаж ажиллах, ажлыг эрчимжүүлэх талаар үүрэгжүүлэхийг,

АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Д.Дамдинбазар нарт:

3.3.Дулааны улирал ирж барилгын ажил эхлэх болсонтой холбогдуулан аймгийн хэмжээнд хийгдэх барилгын салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар судалгааг гаргаж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,

Дөрөв.Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга-д:


4.1.Говийн аймгуудад болон шороон шуурганы талаар судлах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар танилцуулахыг,

Тав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нарт:

5.1.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлын хэсэг, Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангуулан ажиллах ажлын хэсгүүдийг сумдад хамтатган зохион байгуулахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.2.Ой, хээрийн гал түймрийн хөдөлгөөнт хяналтын цэгүүдийг ажиллуулах тухай санал боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,

 / Ч.Ганбат
/ Д.Баттулга

Зургаа.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

6.1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Онцгой комисст ирүүлсэн нэг цонхны үйлчилгээний төвд шаардлагатай нэг удаагийн амны хаалт 200, нүүрний хаалт 6 ширхэг, гар ариутгагч 6 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст олгохыг зөвшөөрөв,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

6.2.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Хилийн Баянхошуу боомтоор тусгай тоноглол бүхий техник, багаж хэрэгслийг нэвтрүүлэх тухай” хүсэлтийг Улсын Онцгой комисст уламжлахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

6.3.Улсын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн хариу албан бичгийг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:

6.4.“Анчэс буйр” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Карго үйлчилгээний 2 тээврийн хэрэгслийн нэмэгдүүлэх тухай” хүсэлтийн дагуу Мэргэжлийн хяналт, авто тээврийн байцаагчийн дүгнэлтийг үндэслэж шийдвэрлэхийг,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг-д:

6.5.Монголын бэлчээр ашиглалтын нэгдсэн холбооноос аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Баян-Уул, Цагаан-Овоо суманд ажиллах тухай” хүсэлтийн дагуу Монгол Улсын Шадар сайдын баталсан 2021 оны 21 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах тохиолдолд зөвшөөрөх тухай чиглэл өгөхийг тус тус үүрэг болгов.

ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ
ДАРГА Ч.ГАНБАТ

ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА *А.Баттулга* Д.БАТТУЛГА

ТУ32095 0720030013 9029346